



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

(2025 оны эхний хагас жилийн байдлаар)

УЛААНБААТАР ХОТ
2025 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗАР

ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН (2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр)



2025 оны 05 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Нэг. Хууль, эрх зүйн үйл ажиллагаа болон сургалт сурталчилгааны чиглэлээр:


1.1. Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 24, хүний нөөцийн чиглэлээр 24 нийт 48 тушаал батлан гаргаж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн эрх зүйн мэдээллийн сан www.ublegal.ulaanbaatar.mn болон байгууллагын <https://tourism.ub.gov.mn/> цахим хуудаст тухай бүр байршуулж ажиллав. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй нийт 178 гэрээ байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

1.2. Байгууллагын <https://tourism.ub.gov.mn/> цахим хуудасны “Хууль, эрх зүй” дэд хэсэгт Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль (шинэчилсэн найруулга) болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг байршуулж, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.



1.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн сургалтад байгууллагын 7 албан хаагчийг, Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтад 3 албан хаагч хамруулав.

Байгууллагын азрын Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох журмыг танилцуулсан гарын авлага бэлтгэж нийт албан хаагчдад танилцуулав.



Хоёр. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр:


2.1. Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг жанжин Д.Сүхбаатарын талбай, Сөүлийн гудамж, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал зэрэг 3 байршилд ажиллуулж 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар гадаад, дотоодын нийт 843 хүнд үйлчилгээ үзүүлж, төвүүдийн байршлыг “Google map” сайт дээр бүртгэлжүүлсэн.



Ж.СҮХБААТАРЫН ТАЛБАЙ




ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН
НИСЭХ БУУДАЛ



СӨҮЛИЙН ГУДАМЖ

2.2. Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглах Улаанбаатар сэтгүүл (Англи, Герман, Япон, Солонгос, Орос, Хятад хэл дээр), Улаанбаатар хотын хөтөч ном (Guide book), жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг (City map) зэрэг 3 төрлийн 24,500 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж Монгол Улсад суугаа гадаад улсуудын Элчин сайдын яамд, консулын газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, зөвлөгөөн, эвент арга хэмжээнүүдэд тарааж үйл ажиллагаагаа сурталчилсан.



2.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Улаанбаатар хотод жуулчин тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, гадаад, дотоодын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангасан зорчих үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр аялал жуулчлалын салбарын төлөөлөлтэй уулзан аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр санал солилцож авч хэрэгжүүлж буй ажлуудаа танилцуулав. Тухайлбал:

“Чингис хаан” олон улсын нисэх буудал руу 45 хүний суудалтай олон улсын стандартыг хангасан 10 автобус нийтийн тээврийн үйлчилгээнд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2 чиглэлд явуулж эхэллээ.



2.4. Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор “Оюутан цагдаа хөтөлбөр”-ийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Монголын Оюутны холбоо хамтран 10 дахь жилдээ хэрэгжүүлж байна.



ОЮУТАН ЦАГДАА ХӨТӨЛБӨР-2025

ОЮУТАН ЦАГДАА - 2025 БҮРТГЭЛ

Нийслэлийн 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл - ийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор, оюутан залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, гадаргаан иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр "Оюутан цагдаа" арга хэмжээг Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын газартай хамтран зохион байгуулах гэж байна.

Явцаа хадгалахын тулд Google-д нэвтрэх. Нэмэлт мэдээлэл авах

* нь шаардлагатай асуултыг заана

1. Таны Овог *

Таны хаягт

2. Таны нэр *

"Оюутан цагдаа-2025" арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 08 дугаар сарын 05-ны өдрийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн арга хэмжээнд оролцох оюутнуудыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс бүртгэж эхлээд байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



D. Batuy

Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

D. Ganbold

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

O. Nyambat

О.НЯМБАТ